

2024 он 09 сар 10 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Э.Пүрэвлхам нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5, 80 дугаар зүйлийн 80.2, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн Э.Пүрэвлхам-ыг 2024 оны 09-р сарын 10-ны өдрөөр тасалбар болгон Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

2024 он 09 сар 10 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5, 77.6, 80 дугаар зүйлийн 80.2, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Б.Цээням-ыг 2024 оны 09-р сарын 10-ны өдрөөс эхлэн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэлх хугацаанд Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсугай.
2. Шинээр томилогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүн /Б.Цээням/-д Компанийн тухай хууль, холбогдох хууль дүрэм журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА